



МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
БОТАНИКИЙН ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН



“300-ААС ДООШГҮЙ ЗҮЙЛ УРГАМЛЫН ЭКОЛОГИ-ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БОЛОВСРУУЛЖ БАТЛУУЛАХ”

/БОУАӨЯ-ны зөвлөх үйлчилгээний ажлын тайлан/

Гүйцэтгэгчид:

Удирдагч, доктор (Ph.D.).....О.Энхтуяа
Зөвлөх, (M. Sc.).....Г.Бүрэнбаатар
Доктор (Ph.D.).....Ц.Бөхчулуун
Доктор (Ph.D.).....Н.Хэрлэнчимэг
Магистр (M.Sc.).....Э.Энхжаргал
Магистр (M. Sc.).....С.Жавхлан

УЛААНБААТАР, 2024

Үр дүн:

Байгаль орчин аялал жуучлалын сайдын “Экологи-эдийн засгийн үнэлгээ батлах тухай” 2022 оны А/603 дугаар тушаалд хамрагдаагүй 300 зүйл ургамлын экологи-эдийн засгийн үнэлгээг боловсруулах” даалгаварт ажлын хүрээнд

- ШУА-ийн Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн эрдмийн зөвлөлөөр 2020 онд шинэчлэн батлагдсан “Экологи-эдийн засгийн үнэлгээ боловсруулах” аргачлалд Хаг, Хөвд, Мөөг, Замагийг үнэлэхэд зориулсан нэмэлт өөрчлөлт оруулж боловсруулсанг тус хүрээлэнгийн 2024.11.22-ны өдрийн Эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлуулав.

- Уг аргачлалаар 118 зүйл мөөг, 100 зүйл хаг, 64 зүйл хөвд, 18 зүйл замгийн борлуулалтын үнэ, бэлтгэх зардал, ажиллах хүчний зардал, нөхөн сэргээх зардал, экологи-эдийн засгийн үнэлгээний итгэлцүүрийн оноо зэргийг тооцож экологийн үнэлгээг 14, эдийн засгийн үнэлгээг 10 буюу нийт 24 бүлэг асуулга, 116 нэгж асуулгын дагуу нэгтгэн боловсруулж нэгтгэв.

- Боловсруулсан аргачлалын асуулга бүрээр 300 зүйл гуурсгүй ургамлын экологи-эдийн засгийн үнэлгээг үнэлж нэгтгэн, үр дүнг 2024 оны 11 сарын 21-ний өдөр нээлттэй хэлэлцүүлэгийг 13 байгууллагын 30 гаруй төлөөлөл оролцуулан зохион байгуулж, олон нийтийн мэдээллийн хэрэгсэлээр сурталчлав.

Тайлбар: Үнэлгээ хийсэн зүйлүүдээс:

- Мөөгний хувьд нэн ховор 6 зүйл, ховор 17 зүйл, элбэг 95 зүйл хамрагдав. Тэдгээрээс хамгийн бага үнэтэйд *Coprinopsis atramentaria* (Саарал шивхэт)-ийн 1000 гр нойтон жингийн үнэлгээ 27414₮ бөгөөд 1000 гр хуурай жингийн үнэлгээ 41121₮ байсан бол хамгийн өндөр үнэтэйд *Auricularia auricula-judae* (Чихэрхүү царцмаг)-ийн 1000 гр нойтон жингийн үнэлгээ 188286 ₮ бөгөөд 1000 гр хуурай жингийн үнэлгээ 338914₮ байна.

- Хөвдний хувьд нэн ховор 24 зүйл, ховор 10 зүйл, элбэг 30 зүйл хамрагдснаас хамгийн бага үнэтэйд *Andreaea heinemannii* (Хейнимана андрее)-ийн 100 гр нойтон жингийн үнэлгээ 57125₮ бөгөөд 100 гр хуурай жингийн үнэлгээ 74262₮ байсан бол хамгийн өндөр үнэтэйд *Dichelyma falcatum* (Хадуураархуу дихелима)-ийн 100 гр нойтон жингийн үнэлгээ 110612₮ бөгөөд 100 гр хуурай жингийн үнэлгээ 199101₮ гарсан байна.

- Замагаас нэн ховор 9 зүйл, ховор 9 зүйл байгаагаас хамгийн бага үнэтэйд *Tolypella mongolica* (Монгол толипелла)-ийн 100 гр нойтон жингийн үнэлгээ 24960₮ бөгөөд 100 гр хуурай жингийн үнэлгээ 47425₮ байсан бол хамгийн өндөр үнэтэйд *Nostoc flagelliforme* (Газрын үс)-ийн 100 гр хуурай жингийн үнэлгээ 2100386₮ байна.

-Хагаас нэн ховор 5 зүйл, ховор 7 зүйл, элбэг 88 зүйл үнэлэгдснээс хамгийн бага үнэтэйд *Hypogymnia austerodes* (Хөшүүн хөөндийхөн)-ийн 100 гр хуурай жингийн үнэлгээ 17760₮ байсан бол хамгийн өндөр үнэтэйд *Acarospora fuscata* (Боргол хадандай)-ийн 100 гр хуурай жингийн үнэлгээ 242815₮ байна.

Дүгнэлт:

Энэхүү үнэлгээнд мөөгнөөс давхцсан тоогоор эмийн 32 зүйл, хүнсний 91, хөвдөөс эмийн 15, гоёл чимэглэлийн 47 зүйл, хагаас эм ба хүнсний 100 зүйл, замагаас идэш тэжээлийн ач холбогдолтой 19 зүйл буюу нийт 300 зүйл гуурсгүй ургамал шинээр үнэлэгдснээр манай оронд ашиглалтанд өртөмтгий, өртөгдөх магадлалтай мөөг, хаг, хөвд, замагийн зүйлүүд тус үнэлгээнд бүрэн хамрагдсан гэж дүгнэж байна